



ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНМӨНХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 1101

Баянмөнх сум

2025 оны цэргийн бүртгэл явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйл, аймгийн Засаг даргын 2024 оны 12 дүгээр сарын 24-ны өдрийн А/675 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэргийн бүртгэлийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:

А.Болормаа

Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүдэд:

Б.Батбаатар

1-р багийн Засаг дарга

М.Содбаяр

2-р багийн Засаг дарга

Ж.Баасансүх

3-р багийн Засаг дарга

Г.Батзориг

4-р багийн Засаг дарга

Нарийн бичгийн

дарга:

Э.Ариундагина

Архив, бичиг хэргийн эрхлэгч

2. 2025 оны Цэргийн бүртгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрүүдэд сумын хэмжээнд зохион байгуулсугай.

3. Цэргийн бүртгэлийг зохион байгуулахдаа цэргийн үүрэгтэн иргэдийг биечлэн болон цахимаар бүртгэж, 2024 оны жилийн эцсийн хүн амын тоотой тулган, цэргийн бүртгэлийн материал, мэдээ судалгааг маягтын дагуу гаргаж, тогтоосон хугацаанд хуваарийн дагуу хүргүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (А.Болормаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  О.НЯМДАВАА